



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Гуулин багийн ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/104/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.4 Зөвлөмж	15
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022. 02. 25 № 105

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалин хөлсний орлогыг нийгмийн даатгалын тайлан, татварын тайланд зөрүүтэй тайлагнасан, тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас худалдан авалт хийсэн, тайлант онд гэрэл, цахилгаан, бичиг хэрэг, цэвэр бохир ус, урсал засварын зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн, татварын тодорхойлолтоорх цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй аудитлгах орлогоос суутгасан татварын авлага, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зэрэг 50.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол, Засгийн азрын 2019 оны 450 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" журам, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

07020382

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,831,294.47	23,992,298.09
33	АВЛАГА	2,276,678.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,276,678.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	10,554,616.47	23,992,298.09
354	Хангамжийн материал	10,554,616.47	23,992,298.09
35410	Бичиг хэргийн материал	278,500.00	298,500.00
35420	Аж ахуйн материал	277,000.00	7,340,735.69
35430	Сэлбэг хэрэгсэл	60,000.00	60,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,706,000.00	4,841,830.00
35450	Барилгын засварын материал	1,349,500.00	3,557,000.00
35460	Хүнсний материал	1,340,115.57	2,792,231.50
35470	Бусад хангамжийн материал	4,543,500.90	5,102,000.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	623,269,889.22	606,781,041.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	623,269,889.22	606,781,041.09
392	Биет хөрөнгө	597,889,621.41	581,422,773.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	685,909,998.70	685,909,998.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(108,444,574.72)	(124,081,958.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,737,002.00	143,620,092.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	(118,704,766.88)	(136,585,309.55)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,495,921.04	44,001,521.04
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,424,573.95)	(40,958,541.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,358,300.00	15,358,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(10,786,466.62)	(14,590,110.85)
39217	Ном	8,748,781.84	8,748,781.84
393	Биет бус хөрөнгө	25,380,267.81	25,358,267.85
39301	Програм хангамж	918,000.00	918,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(849,332.19)	(871,332.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	25,311,600.00	25,311,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	636,101,183.69	630,773,339.18
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	287,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	287,000.00	-
413	Өглөг	287,000.00	-
4136	Бусад өглөг	287,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	100,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	187,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	635,814,183.69	630,773,339.18
51	Засгийн газрын хувь оролцоо	635,814,183.69	630,773,339.18
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	184,358,734.84	184,358,734.84
51101	Өмч: - төрийн	184,358,734.84	184,358,734.84
512	Хуримтлагдсан үр дүн	(128,877,305.73)	(133,918,150.24)
51210	Өмнөх үеийн үр дүн	(128,877,305.73)	(128,877,305.73)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,040,844.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	580,332,754.58	580,332,754.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	636,101,183.69	630,773,339.18

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	635,285,206.00	646,154,179.17
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,730,998.00	28,276,748.17
Нийтлэг татварын бус орлого	13,730,998.00	28,276,748.17
Төсөв байгууллагын өөрийн орлого	13,730,998.00	28,276,748.17
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,730,998.00	28,276,748.17
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		22,588,690.48
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал		5,688,057.69
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,554,208.00	617,877,431.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	590,236,200.00	581,137,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,302,308.00	4,392,731.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хяналт авсан хөрөнгө	6,302,308.00	4,392,731.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,015,700.00	32,346,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,015,700.00	32,346,900.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	679,088,670.84	651,195,023.68
УРСГАЛ ЗАРДАЛ	679,088,670.84	651,195,023.68
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,362,353.57	639,460,536.31
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	485,469,443.57	482,240,413.77
Үндсэн цалин	408,954,860.43	412,280,627.64
Урамшуулал	39,970,067.11	26,669,565.11
Гэрээт ажлын хөлс	36,544,516.03	43,290,221.02
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,841,895.14	66,707,889.62
Тэтгэврийн даатгал	45,371,662.57	47,246,102.18
Тэтгэмжийн даатгал	960,000.00	4,748,098.29
ҮОМШӨ-ний даатгал	3,844,312.85	4,218,428.05
Ажилгүйдлийн даатгал	968,792.75	979,187.70
Эрүүл мэндийн даатгал	9,697,126.97	9,516,073.40
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,274,727.00	26,987,994.24
Гэрэл, цахилгаан	3,479,480.00	4,952,494.24
Түлш, халаалт	25,795,247.00	21,435,500.00
Цэвэр, бохир ус	1,000,000.00	600,000.00
Хангамж, бараа материалын зардал	8,657,418.85	2,478,481.00
Бичиг хэрэг	580,800.00	859,431.00
Тээвэр, шатахуун	1,510,860.00	665,350.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	48,000.00	100,000.00
Ном, хэвлэл	-	56,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	57,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,142,758.85	740,700.00
Нормативт зардал	17,815,403.00	13,324,319.07
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	409,862.00	1,064,600.00
Хоол, хүнс	17,405,541.00	11,991,119.07
Нормын хувцас, зөөлөн эдлэл		268,600.00
Эд хогшил, урсгал засварын зардал	394,000.00	2,000,300.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	394,000.00	621,300.00
Урсгал засвар	-	1,379,000.00
Томиллолт, зочны зардал	-	250,000.00
Дотоод албан томиллолт	-	250,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,741,000.00	240,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	945,000.00	240,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	42,168,466.01	45,231,138.61
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	3,353,600.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодог	41,168,466.01	41,877,538.61
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,726,317.27	11,734,487.37
Бусад урсгал шилжүүлэг	8,757,308.00	10,362,025.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,972,525.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс олгох тэтгэмж, урамшуулал	4,357,308.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,400,000.00	4,389,500.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	320,120.00	247,625.76
Төвлөрүүлэх шилжүүлэг	320,120.00	247,625.76
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,648,889.27	1,124,836.61
Төвлөрүүлэх шилжүүлэг	22,648,889.27	1,124,836.61
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(43,803,464.84)	(5,040,844.51)
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	43803464.84	(5,040,844.51)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-128,877,305.73	0.00	635,814,183.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-128,877,305.73	0.00	635,814,183.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-128,877,305.73	0.00	635,814,183.69
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-128,877,305.73	0.00	635,814,183.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-128,877,305.73	0.00	635,814,183.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,040,844.51	0.00	-5,040,844.51
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,358,734.84	580,332,754.58	-133,918,150.24	0.00	630,773,339.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	621,554,208.00	617,877,431.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	621,554,208.00	617,877,431.00
Улсын төвлөрсөн төсвөөс	590,236,200.00	581,137,800.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	590,236,200.00	581,137,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,302,308.00	4,392,731.00
Дэд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,302,308.00	4,392,731.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,015,700.00	32,346,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,015,700.00	32,346,900.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	621,554,208.00	615,077,431.00
УРСГАЛ ЗАРДАЛ	621,554,208.00	615,077,431.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	587,018,760.73	602,462,168.63
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	485,469,443.59	482,240,413.77
Үндсэн цалин	408,954,860.43	398,830,697.20
Урамшуулал	39,970,067.11	34,659,017.25
Гэрээт ажлын хөлс	36,544,516.05	48,750,699.32
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,841,895.14	66,707,889.62
Тэтгэврийн даатгал	45,371,662.57	47,246,102.18
Төлбөмжийн даатгал	960,000.00	4,748,098.29
ҮОМШӨ-ний даатгал	3,844,312.85	4,218,428.05
Ажилгүйдлийн даатгал	968,792.75	979,187.72
Эмгүүл мэндийн даатгал	9,697,126.97	9,516,073.38
Байршиглалттай холбоотой тогтмол зардал	24,695,580.00	29,099,274.24
Гэрэл, цахилгаан	3,479,480.00	4,952,494.24
Түнд, халаалт	20,216,100.00	23,546,780.00
Цавар, бохир ус	1,000,000.00	600,000.00
Хангамж, бараа материалын зардал	3,818,870.00	2,137,131.00
Бичиг хэрэг	323,000.00	270,431.00
Төмөр, шатахуун	1,510,860.00	497,000.00
Шалдан, холбоо, интернэтийн төлбөр	48,000.00	100,000.00
Нас, хэвлэл	150,000.00	150,000.00
Хөдөлгөөнд зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	375,000.00	249,900.00
Бусад үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,412,010.00	869,800.00
Нормативт зардал	8,752,172.00	14,327,460.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	483,862.00	1,654,500.00
Хоол, хүнс	8,268,310.00	12,572,960.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	100,000.00
Эдийлжил, урсгал засварын зардал	442,000.00	3,640,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	442,000.00	640,000.00
Урсгал засвар	-	3,000,000.00
Төмөрлөлт, зочны зардал	-	250,000.00
Дотоод албан томиллолт	-	250,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,741,000.00	340,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	945,000.00	340,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
Бараа үйлчилгээний бусад зардал	1,257,800.00	3,720,000.00
Хөдөө үйлдвэрлэлийн дадлага хийх	1,257,800.00	3,720,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,535,447.27	12,615,262.37
Бусад урсгал шилжүүлэг	11,566,438.00	11,242,800.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,809,130.00	6,842,800.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алоан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,357,308.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,400,000.00	4,400,000.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	320,120.00	247,625.76
Төвлөрүүлэх шилжүүлэг	320,120.00	247,625.76
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,648,889.27	1,124,836.61
Төвлөрүүлэх шилжүүлэг	22,648,889.27	1,124,836.61
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	2,800,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,800,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,800,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	2,800,000.00
Бусад ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,800,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(2,800,000.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	613,484,700.00	612,112,237.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	613,484,700.00	612,112,237.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	602,237,600.00	600,869,437.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,675,700.00	482,240,413.77
210101	Үндсэн цалин	398,779,200.00	398,830,697.20
210104	Урамшуулал	35,145,800.00	34,659,017.25
210105	Гэрээт ажлын хөлс	48,750,700.00	48,750,699.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	67,390,200.00	66,707,889.62
210201	Тэтгэврийн даатгал	50,133,700.00	47,246,102.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,687,500.00	4,748,098.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,094,000.00	4,218,428.05
210204	Ажилгүйдлийн даатгал	769,000.00	979,187.72
210205	Эрүүл мэндийн даатгал	7,706,000.00	9,516,073.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,346,900.00	29,099,274.24
210301	Гэрэл, цахилгаан	5,200,000.00	4,952,494.24
210302	Түлш, халаалт	23,546,900.00	23,546,780.00
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,046,800.00	2,044,400.00
210401	Бичиг хэрэг	179,800.00	177,700.00
210402	Тээвэр, шатахуун	497,000.00	497,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,000.00	100,000.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	250,000.00	249,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	870,000.00	869,800.00
2105	Нормативт зардал	14,328,000.00	14,327,460.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,655,000.00	1,654,500.00
210502	Хоол, хүнс	12,573,000.00	12,572,960.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,440,000.00	5,440,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	1,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640,000.00	640,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	250,000.00	250,000.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	250,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	340,000.00	340,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	340,000.00	340,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	420,000.00	420,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	420,000.00	420,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,247,100.00	11,242,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,247,100.00	11,242,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,847,100.00	6,842,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,400,000.00	4,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	613,484,700.00	612,112,237.63
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	581,137,800.00	580,012,963.39
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	581,137,800.00	580,012,963.39
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,346,900.00	32,099,274.24
132001	Орон нутгийн төсвөөс	32,346,900.00	32,099,274.24

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,302,308.00	4,392,731.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,302,308.00	4,392,731.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,945,000.00	4,392,731.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	92,731.00
210401	Бичиг хэрэг	-	92,731.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,330,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,330,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	945,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	945,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	2,970,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	2,970,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,357,308.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,357,308.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,357,308.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,302,308.00	4,392,731.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,302,308.00	4,392,731.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,302,308.00	4,392,731.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж хүргүүлээ.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын захирал, аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэмд заасны дагуу Дэлгэр сумын Гуулин тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсролтой, ёс зүй, төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх хөгжүүлэхэд оршино”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын

талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 635.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.2 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлгэр сумын Гуулин багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.5 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс, өглөг данс байна. байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18.8 сая төгрөг болж 6.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 49.2 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.5 сая төгрөгийн, авлага барагдуулж 2.3 сая төгрөгийн бараа материал орлого авч, үйл ажиллагаандаа 43.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 924.0 сая төгрөг болж 25.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.8 сая төгрөг, хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 22.6 сая төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Засгийн газрын эрлцоо дансны үлдэгдэл 625.6 сая төгрөг болж 10.2 сая төгрөгөөр буурсан байна. Орлого өмнөх оноос 6.5 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 139.1 сая төгрөгийн алдагдалтай болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 668.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 55.2 сая төгрөгөөр бууруулж, 613.4 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал (1500 төгрөг) болж өссөнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхээр 613.4 сая төгрөгийн төсөв баталснаас 581.1 сая төгрөгийг улсын төсвөөс 32.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 581.1 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 32.3 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 613.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 612.1 сая төгрөгийг зарцуулж 1.1 сая төгрөгийг улсын төсөвт, 0.2 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 612.1 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 0.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.7 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.2 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 4.4 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс бичиг хэргийн зардал 0.1 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 3.0 сая төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 1.3 сая төгрөг зарцуулж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 689.0 сая төгрөгийн 155 мэдээллийг ил тод байршуулахаас 613.4 сая төгрөгийн 148 мэдээллийг ил тод байршуулсанаас 19 мэдээллийг хугацаа хоцроосон байна. 75.6 сая төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй байна. Мэдээллийн 89 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 5.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар

- Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгийн үнэ, шинж чанарт дүн шинжилгээ хийх
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 50.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнээс 29.4 сая төгрөгийн зөрчлийн залруулж, 20.7 сая төгрөгт албан шаардлага, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй, авлага барагдуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Цалин хөлсний орлогыг татварын тайланд 24.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд бий нийлүүлсэн 5.1 сая төгрөгийн хөрөнгийг орлого авч аудитын явцад залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Цалин хөлсний орлогыг нийгмийн даатгалын тайланд 4.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1-т /хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;/ заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Цалин хөлсний орлогыг татварын тайланд 2.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь ХХОАТ-ын тухай хуулийн 7дугаар зүйл, 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тендерт шалгараагүй иргэн ААНБ-аас 3.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 7 дугаар зүйлийн 7.1-т “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд 6.5 сая төгрөгийн гэрэл, цахилгаан, бичиг хэрэг, цэвэр бохир ус, урсал засварын зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө” заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2. журналд бичих, 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах, заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

